# МОНГОЛ УЛСЫН
# БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
# САЙДЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 07 өдөр        Дугаар 110        Улаанбаатар хот

Ажиллагсдын ажлын орчин нөхцөлийн
Жендэрийн мэдрэмжийг үнэлэх тоон болон
чанарын багц шалгуур үзүүлэлт,
шалгах хуудсыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт, Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан "Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого"-ыг хэрэгжүүлэх зорилгоор тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Салбарын "Ажиллагсдын ажлын орчин нөхцөлийн Жендэрийн мэдрэмжийг үнэлэх тоон болон чанарын багц шалгуур үзүүлэлт"-ийг нэгдүгээр хавсралтаар, "Ажилчдын байрны шалгах хуудас"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан тоон болон чанарын багц шалгуур үзүүлэлт, шалгах хуудасны дагуу мэдээллийг салбарын аж ахуйн нэгж байгууллага, харьяа төслийн нэгжүүдээс гаргуулах, дүгнэлт хийх, бодлого чиглэлд тусгах үйл ажиллагааг зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Ц.Гансүх)-т даалгасугай.

3. Салбарын аж ахуйн нэгж, байгууллага, харьяа төслийн нэгжүүд батлагдсан тоон болон чанарын багц шалгуур үзүүлэлт, шалгах хуудасны дагуу тухайн хагас жилийн мэдээг 07 дугаар сарын 20-ны дотор, жилийн эцсийн мэдээг дараа оны 02 дугаар сарын 21-ний өдрийн дотор "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-т ирүүлж ажиллахыг даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбатад үүрэг болгосугай.

Ц.ДАВААСҮРЭН

152410291

Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны
06. дугаар сарын 07-ны өдрийн 110 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

# АЖИЛЛАГСДЫН АЖЛЫН ОРЧИН НӨХЦЛИЙН ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖИЙГ ҮНЭЛЭХ ТООН БОЛОН ЧАНАРЫН БАГЦ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

.... оны ... сарын ... өдөр

Байгууллагын нэр, утасны дугаар:……………………………………………………………

Үйл ажиллагааны чиглэл:..................................................................................................

Байршил (Хаяг):................................................................................................................

Холбогдох албан хаагчийн нэр:.........................................................................................

Албан тушаал, утасны дугаар:..........................................................................................

1. Байгууллагын бодлого, зохион байгуулалтын баримт бичигт туссан жендэрийн мэдрэмжийн үзүүлэлт:

| № | Үзүүлэлт | Тусгагдаагүй | Сайжруулах шаардлагатай | Хангалттай | Үнэлгээний үндэслэл |
|---|---|---|---|---|---|
| A | Үнэлгээ (Оноо) | 0 | 3 | 5 | |
| 1 | Байгууллагын стратеги, бизнес үйл ажиллагааны төлөвлөгөө, хүний нөөцийн бодлогод хүний эрх жендэрийн тэгш байдлыг хангах зарчим хэм хэмжээ тусгагдсан эсэх | | | | |
| 2 | Байгууллагын тухайн жилийн бизнес төлөвлөгөөнд хүний эрх, жендэрийн тэгш байдлыг хангах зорилт, арга хэмжээ тусгагдсан эсэх | | | | |
| 3 | Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд хүний эрх, жендэрийн тэгш байдлыг хангах зарчим хэм хэмжээ тусгагдсан эсэх | | | | |
| 4 | Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд хүний эрх, жендэрийн тэгш байдлыг хангах ажил | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | олгогчийн эрх, үүргийг тусгасан эсэх | | | | |
| 5 | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд эрэгтэй эмэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг харгалзан ажил ар гэрийн тэнцвэрийг хангах зарчим,хэм хэмжээ тусгагдсан эсэх | | | | |
| 6 | Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд хүүхдийн хөдөлмөрийн талаар холбогдох зарчим, шаардлага хэм хэмжээ тусгагдсан эсэх | | | | |
| 7 | Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн талаар холбогдох зарчим шаардлага хэм хэмжээ тусгагдсан эсэх | | | | |
| 8 | Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд ажлын байрны дарамт, бэлгийн дарамтаас сэргийлэх, гомдлыг шийдвэрлэх механизм тусгагдсан эсэх | | | | |
| 9 | Ажилтан албан хаагч, үйлчлүүлэгч иргэд, гуравдагч этгээдээс гаргасан гомдлыг хүлээн авч, барагдуулах хэм хэмжээг тусгасан тусгай баримт бичигтэй эсэх | | | | |
| 10 | Ажилтан албан хаагч, үйлчлүүлэгч иргэд, | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | гуравдагч этгээдээс гаргасан гомдлыг хүлээн авч, барагдуулах хэм хэмжээг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгасан эсэх | | | | |
| 11 | Байгууллагын Хөдөлмөрийн гэрээнд ажлын байрны дарамт, бэлгийн дарамтыг ноцтой зөрчилд тооцдог эсэх | | | | |
| 12 | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт, байгууллагын ажиллагчдын сэтгэл ханамжийн судалгаа авах талаар хөдөлмөрийн дотоод журамд тусгагдсан эсэх | | | | |

2. Байгууллагын статистик мэдээлэл болон төлөвлөлт, төсөвлөлтийн жендэрийн мэдрэмжийн үзүүлэлт:

| № | Үзүүлэлт | Байхгүй | Сайжруулах шаардлагатай | Хангалттай | Үнэлгээний үндэслэл |
|---|---|---|---|---|---|
| А | Үнэлгээ (Оноо) | 0 | 3 | 5 | |
| 1 | Ажиллагчдын нийгэм, эдийн засаг, гэр бүлийн асуудлаарх хүйс, нас, орлого, боловсрол, оршин суугаа байршил гэх мэт өргөтгөсөн үзүүлэлтээр гаргасан жендэрийн статистикийг цуглуулж нэгтгэдэг эсэх (жендэрийн тоон болон чанарын үзүүлэлт) | | | | |
| 2 | Жендэрийн тэгш байдал, жендэрийн статистик үзүүлэлт, өгөгдлийг цуглуулах чиг үүргийг ажлын байрны чиг үүрэгт | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | тусгасан эсэх, хариуцсан ажилтан томилсон эсэх | | | | |
| 3 | Жендэрийн статистик үзүүлэлт, өгөгдөл мэдээллийг албан хаагчдад нээлттэй ил тод тархаадаг эсэх | | | | |
| 4 | Жендэрийн статистик үзүүлэлт, өгөгдөл мэдээллийг бодлого боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх , тайлагнах бүх үе шатанд ашигладаг эсэх | | | | |
| 5 | Хөтөлбөр, арга хэмжээ, бүтээгдэхүүн үйлчилгээний үр шим хүртэгчдийн хүйсээр ангилсан өгөгдөл мэдээлэл гаргадаг эсэх | | | | |
| 6 | Хөтөлбөр, арга хэмжээ, бүтээгдэхүүн үйлчилгээний үр шим хүртэгчдийн хүйсээр ангилсан өгөгдөл мэдээллийг бодлого боловсруулах төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, тайлагнах бүх үе шатанд ашигладаг эсэх | | | | |
| 7 | Байгууллагын бодлого төлөвлөлт, стратеги, бизнес төлөвлөгөөний жендэрийн агуулгыг судлах, түүний зориулсан төсвийн төлөвлөлт хийгдсэн эсэхэд жендэрийн шинжилгээ хийдэг эсэх | | | | |
| 8 | Төсвийн төлөвлөлт, хэрэгжилтэд хийсэн жендэрийн шинжилгээг дараагийн шатны төлөвлөлт, төсөвлөлтөд ашигладаг эсэх | | | | |

Байгууллагын хүйсээр ангилсан статистик мэдээлэл:

| Үзүүлэлт | | | Эрэгтэй | | Эмэгтэй | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Тоо | Хувь | Тоо | Хувь |
| Нийт | | | | | | |
| Үүнээс; | Байгууллагын нийт ажиллагсдын мэдээлэл | НА | | | | |
| | Удирдах ажилтан | УА | | | | |
| | Гүйцэтгэх ажилтан | ГА | | | | |
| | | | | | | |
| | Мэргэжилтэй ажилтан | МА | | | | |
| | Туслах ажилтан | ТА | | | | |
| | Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон | ӨНТТ | | | | |
| | Хөгжлийн бэрхшээлтэй хүн | ХБХ | | | | |
| | Насанд хүрээгүй ажилтан | НХА | | | | |
| | Жирэмсэн эмэгтэй | ЖЭ | | | | |
| | 0-3 хүртэлх насны хүүхэдтэй эцэг, эх | 0-3 | | | | |
| | 4 хүртэлх насны ихэр хүүхэдтэй эх, эцэг | ИХЭЭ | | | | |
| | 3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг | ӨТЭЭ | | | | |

Байгууллагын хүйсээр ангилсан төсвийн зардлын шинжилгээ:

| Үзүүлэлт | | | | Нийт | Үүнээс | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | НА | УА | ГА | МА | ТА | ӨНТТ | ХБХ | НХА | ЖЭ | 0-3 | ИХЭЭ | ӨТЭЭ |
| Батлагдсан төсөв | | | | | | | | | | | | | | | | |
| Нийт гүйцэтгэл | | | | | | | | | | | | | | | | |
| Үүнээс | Цалин (дун даж) | тоо | Эм | | | | | | | | | | | | | |
| | | | эр | | | | | | | | | | | | | |
| | | Хувь | Эм | | | | | | | | | | | | | |
| | | | эр | | | | | | | | | | | | | |
| | Шагнал урамшуулал | тоо | Эм | | | | | | | | | | | | | |
| | | | эр | | | | | | | | | | | | | |
| | | Хувь | Эм | | | | | | | | | | | | | |
| | | | эр | | | | | | | | | | | | | |
| | Тэтгэмж | тоо | Эм | | | | | | | | | | | | | |
| | | | эр | | | | | | | | | | | | | |
| | | хувь | Эм | | | | | | | | | | | | | |
| | | | эр | | | | | | | | | | | | | |
| | Нормын хувцас /иж бүрэн/ | тоо | Эм | | | | | | | | | | | | | |
| | | | эр | | | | | | | | | | | | | |
| | | хувь | Эм | | | | | | | | | | | | | |
| | | | эр | | | | | | | | | | | | | |
| | Нормын хувцас /хэсэгчлэн/ | тоо | Эм | | | | | | | | | | | | | |
| | | | эр | | | | | | | | | | | | | |
| | | хувь | Эм | | | | | | | | | | | | | |
| | | | эр | | | | | | | | | | | | | |

3. Байгууллагын жендэрийн мэдрэмжтэй ажлын биет орчин:

| № | Үзүүлэлт | Хангаагүй | Сайжруулах шаардлагатай | Хангалттай |
|---|---|---|---|---|
| А | Үнэлгээ (Оноо) | 0 | 3 | 5 |
| 1 | Ажилчдын орон байр (үүнд: хоолны заал, ариун цэврийн өрөө, хувцас солих өрөө, дотуур байр, хоргодох байр, яаралтай тусламжийн өрөө, хүүхэд хөхүүлэх өрөө, амрах өрөө, уулзалтын өрөө, сургалтын өрөө гэх мэт)-ны заавал байх ёстой шаардлагыг тодорхойлж мөрдүүлсэн эсэх | | | |
| 2 | Гэрээсээ хол ажиллаж буй ажиллагчдад гэр бүлээрээ байрлах орон байраар хангасан эсэх | | | |
| 3 | Эрэгтэй эмэгтэй хүмүүст зориулсан унтлагын газар тусдаа байдаг эсэх | | | |
| 4 | Эрэгтэй эмэгтэй хүмүүст зориулсан ариун цэврийн газар тусдаа байдаг эсэх | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | Эрэгтэй эмэгтэй хүмүүст зориулсан бие засах газар тусдаа байдаг эсэх | | | |
| 6 | Эрэгтэй эмэгтэй хүмүүст зориулсан хувцас солих өрөө тусдаа байдаг эсэх | | | |
| 7 | Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажиллах нөхцөл боломж (орц гарц, ариун цэврийн өрөө гэх мэт) хангагдсан эсэх | | | |
| 8 | Гэрэлтүүлэг бүрэн хийгдсэн эсэх | | | |
| 9 | Камержуулалт бүрэн хийгдсэн эсэх | | | |
| 10 | Ажилдаа ирэх очих унаа ( ажиллагчдын автобус) -гаар үйлчилдэг эсэх | | | |

*Тайлбар:*

Байгууллагын бодлого, зохион байгуулалтын баримт бичгүүдтэй нэг бүрчлэн танилцаж, уг баримт бичгүүдэд;

- Дээрх ойлголт, үзүүлэлтүүд огт тусгагдаагүй бол 0 оноо
- Нэр томъёог тусгаж, анхан түвшний ойлголт, хандлага, мэдрэмжтэй байвал “Сайжруулах шаардлагатай” гэж үзэн 3 оноо
- Холбогдох хууль, тогтоомж, тогтоол, шийдвэр, заавар, зөвлөмжийн хүрээнд тусгаж, ойлголт, хандлага төлөвшссөн бол “Хангалттай” буюу 5 оноогоор тус тус үнэлнэ.

Үнэлсэн албан хаагч тэмдэглэл хөтөлж, үнэлгээг баталгаажуулна.

*Нэр томьёоны тайлбар:*

| | |
|---|---|
| Зохион байгуулалтын баримт бичиг[2] | Албан даалгавар, Зарлиг, Тушаал, Захирамж, Тогтоол, Шийдвэр, Акт, Албан бичиг, Гэрээ, Дүгнэллт, Дүрэм, Журам, Заавар, Зөвлөмж, Илгээлт, Санал, Санамж бичиг, Тайлан, Төлөвлөгөө, Удирдамж, Хөтөлбөр, Хурлын тэмдэглэл, Илтгэх хуудас, Мэдэгдэл, Мэдээ, Танилцуулга, Тодорхойлолт гэх мэт баримт бичиг. |
| Удирдах ажилтан[3] | Удирдах ажилтанд дарга, захирал, дэд захирал, эрхлэгч, менежер орно. |
| Гүйцэтгэх ажилтан[4] | Гүйцэтгэх ажилтанд инженер, техникийн ажилтан, архитектор, барилгын коструктор инженер, технологич инженер, усан хангамж, ариутгах татуургын инженер, халаалт, салхивчийн инженер, цахилгааны инженер, автоматикийн инженер, |

---

[2] MNS 5140-2:2011 Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичиг

[3 4 5] Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан тушаал 206, А/184

| | |
|---|---|
| | холбоо дохиоллын инженер, зургийн техникч гэх мэт орно. |
| Мэргэжилтэй ажилтан[5] | Туслах ажилтанд өргөгч, угсрагч, мужаан, гагнуурчин, засал чимэглэлчин, бетон арматурчин зэрэг барилгын чиглэлийн мэргэжилтэй ажилчин орно. |
| Туслах ажилтан[6] | Туслах ажилтанд барилгын ажилд туслан оролцож буй мэргэжилтэй ажилтнаас бусад ажилчин орно. |
| Насанд хүрээгүй ажилтан[7] | Хуульд заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд оролцож байгаа 18 насанд хүрээгүй хүнийг хэлнэ. |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүн[8] | Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ. |

---oOo---

[7] Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.6
[8] Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1

Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 110 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## Ажилчдын байрны төрөл

| Ангилал | Дэд ангилал | Зориулалт | Салбар | Анхаарах хүчин зүйлс |
|---|---|---|---|---|
| Барилгачдын ажлын байр | Ажилчдын дотуур байр<br>Ажилчдын хотхон<br>Зөөврийн ажилчдын байр | байнгын,<br>урт хугацааны,<br>гэр бүлийн | иргэн,<br>дэд бүтэц,<br>үйлдвэрлэлийн барилга угсралтын төсөл | стандартын хэрэгжилт, хяналт, шалгалт, амьжиргааны түвшин, цалин хөлс |

Байгууллагын нэр, утасны дугаар:........................................................
Үйл ажиллагааны чиглэл: ...................................................................
Байршил (Хаяг):...............................................................................
Холбогдох албан хаагчийн нэр:.........................................................
Албан тушаал, утасны дугаар: ..........................................................

## Ажилчдын байрны шалгах хуудас

| Эрх зүйн зохицуулалт | Тийм | Үгүй | Хамаарахгүй | Тайлбар |
|---|---|---|---|---|
| Ажилчдын байртай холбоотой заавал мөрдөх заалтуудыг тодорхойлсон уу? | | | | |
| **Ажилчдын байрны хэрэглээг үнэлэх** | | | | |
| **Ажиллах хүчний хүртээмж** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Орон нутгаас авах ажилчдын бэлэн байдлыг судалсан уу? | | | | |
| Орон нутгийн ажиллах хүчний ур чадвар, чадамжийн талаар судалж, тэдгээр нь төслийн хэрэгцээнд нийцэх эсэхийг үнэлсэн үү? | | | | |
| Төслийн хэрэгцээнд тулгуурлаж орон нутгаас боловсон хүчин бэлтгэх боломжийн талаар үнэлгээ хийсэн үү? | | | | |
| **Орон байрны хүртээмж** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Ажилчдын байр барихаас өмнө тухайн орон нутагт ажилчдыг байрлуулахад тохиромжтой бэлэн орон сууц байгаа эсэхийг судалсан эсэх | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Бэлэн байгаа байрыг ашигласнаар орон нутагт ямар нөлөө үзүүлэхийг үнэлсэн үү? | | | | |
| Байгаль орчин, нийгмийн менежментийг төлөвлөгөөнд орон нутгийн орон суууцны зах зээлд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ тусгагдсан эсэх | | | | |
| **Ажилчдын байртай холбоотой орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Ажилчдын байртай холбоотой орон нутгийн иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эерэг үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор төслийн байгаль, нийгэм, жендэрийн нөлөөллийн хүрээнд олон нийтэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийсэн үү? | | | | |
| Ажилчдын байр барих үе шатанд газар чөлөөлөх, албадан нүүлгэн шилжүүлэх зэрэгт учирч болзошгүй эрүүл мэнд, аюулгүй байдлын нөлөөлөл, үр дагаврыг үнэлгээнд тусгасан уу? | | | | |
| Үнэлгээнд ажилчдын байртай холбоотой орон нутгийн дэд бүтэц, үйлчилгээ, байгууламжид үзүүлэх нөлөөллийг тусгасан уу? | | | | |
| Үнэлгээнд орон нутгийн бизнес болон орон нутгийн хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөөллийг тусгасан уу? | | | | |
| Үнэлгээнд ажилчдын байртай холбоотой иргэдийн эрүүл мэндэд (ялангуяа зам тээврийн осол, халдварт өвчний эрсдэл нэмэгдэх) болон нийгмийн эв нэгдэлд үзүүлэх ерөнхий нөлөөллийг тусгасан уу? | | | | |
| Үнэлгээнд илэрсэн сөрөг нөлөөллийг арилгахад чиглэсэн зохих арга хэмжээг тусгасан уу? | | | | |
| **Ажилчдын орон байр** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Гэр бүлээр ажиллуулах тохиолдолд орон байраар хангасан үү? | | | | |
| Гэр бүлээр нь ажиллахад унтлагын өрөө, ариун цэврийн болон гал тогоотой байраар хангасан уу? | | | | |
| Цэцэрлэг/сургуультай юу? | | | | |
| Хүүхдийн аюулгүй байдлыг хангахад онцгой анхаарч байна уу? | | | | |
| **Ажлын байрны стандарт** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Холбогдох үндэсний/орон нутгийн зохицуулалтыг тодорхойлж, хэрэгжүүлсэн үү? | | | | |
| **Ажлын байрны орчин** | | | | |
| Байгууламжийн байршил нь үер болон бусад байгалийн аюулд өртөхөөргүй газар байрласан уу? | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Амьдрах байгууламж нь ажлын талбайгаас зохистой зайд байрладаг уу? | | | | |
| Ажлын талбай руу аюулгүй, үнэ төлбөргүй унаагаар үйлчилдэг үү? | | | | |
| Ажлын байрыг тохиромжтой материалаар барьж нь засвар үйлчилгээ сайтай, цэвэрхэн, хог хаягдалгүй байлгадаг уу? | | | | |
| **Ус зайлуулах** | | | | |
| Ажлын талбайд хангалттай ус зайлуулах хоолойтой юу? | | | | |
| **Халаалт, агааржуулагч, агааржуулалт, гэрэлтүүлэг** | | | | |
| Уур амьсгалын онцлогоос шалтгаалаад ажилчдын байрыг халаалт, агааржуулалт, гэрэлтүүлэг, аваарын гэрэлтүүлэг зэргээр хангадаг уу? | | | | |
| **Ус** | | | | |
| Ажилчид ундны болон хэрэглээний цэвэр усыг хялбар, хүртээмжтэй байлгадаг уу? | | | | |
| Усны чанар үндэсний/орон нутгийн шаардлага эсвэл ДЭМБ-ын стандартад нийцэж байна уу? | | | | |
| Ундны ус хадгалах зориулалтын савнууд байршуулж усыг бохир, халдвараас хамгаалж сайтар тагласан уу? | | | | |
| Ундны усны чанарт тогтмол хяналт тавьдаг уу? | | | | |
| **Бохир ус, хатуу хог хаягдал** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Хаягдал ус, бохир ус, хоол хүнс болон бусад хаягдал материалыг орон нутгийн болон Дэлхийн банкны стандартын дагуу ажилчид, хүрээлэн буй орчин, орон нутгийн иргэдэд ноцтой хохиролгүйгээр зайлуулдаг уу? | | | | |
| Хогны зориулалтын савыг байршуулж, тогтмол цэвэрлэдэг уу? | | | | |
| Амьдрах орчныг бүхэлд нь хортон шавьж устгах, сэргийлэх, халдваргүйжүүлэх ажлыг хийдэг үү? | | | | |
| **Өрөө / дотуур байр** | | | | |
| Ажиллаж амьдрахад тохиромжтой гэр, сууц, өрөө, дотуур байртай юу? | | | | |
| Өрөө/дотуур байрыг тогтмол агааржуулж, цэвэрлэдэг үү? | | | | |
| Өрөө/дотуур байрыг угаахад хялбар шалтай барьсан уу? | | | | |
| Өрөө/дотуур байртай ариун цэврийн байгууламж нэг дор байдаг уу? | | | | |
| Ажилчдад ногдох талбай хангалттай юу? | | | | |
| Таазны өндөр хангалттай юу? | | | | |
| Нэг өрөөнд/дотуур байран дахь ажилчдын тоог аль болох бага байлгадаг уу? | | | | |
| Хаалга, цонх нь түгжих, шаардлагатай бол ялаа, шумуулаас хамгаалах боломжтой юу? | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Шаардлагатай үед халхлах дугуйтай хаалт эсвэл хөшиг бий юу? | | | | |
| Ширээ, сандал, толь, ширээний гэрэл зэрэг тавилга хэрэгслийг ажилчин бүрт хүртээмжтэй хангасан уу? | | | | |
| Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн унтлагын өрөө тусдаа байдаг уу? | | | | |
| **Ор, хувцасны шүүгээ** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Ажилчин бүрт тусдаа ор өгдөг үү? | | | | |
| Нэг ор ээлжилж хэрэглэхийг хориглодог уу? | | | | |
| Ор хооронд хамгийн багадаа 1 метр зайтай юу? | | | | |
| Давхар орны хэрэглээг бага байлгадаг уу? | | | | |
| Давхар ортой үед давхарын хооронд хангалттай зай байгаа юу? | | | | |
| Гурван давхар ортой байхыг хориглодог уу? | | | | |
| Ажилчдад тав тухтай гудас, дэр, цэвэр ор хөнжлийн даавуугаар хангасан уу? | | | | |
| Орны цагаан хэрэглэлийг байнга угааж, зохих ариутгалын бодисоор цэвэрлэдэг үү? | | | | |
| Хувийн эд зүйлсээ хадгалахад тохиромжтой шүүгээгээр хангасан уу? | | | | |
| Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг тусдаа агуулах, нөхцөл байдлаас хамаарч хатаах/агааржуулах газар байдаг уу? | | | | |
| **Ариун цэврийн байгууламж** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Ариун цэврийн байгууламжийг цэвэрлэхэд хялбар материалаар хийсэн үү? | | | | |
| Ариун цэврийн байгууламжийг тогтмол цэвэрлэж, хэрэглэхэд тохиромжтой байлгадаг уу? | | | | |
| Ариун цэврийн өрөө, шүршүүр/угаалгын өрөө болон бусад ариун цэврийн байгууламжууд нь таазаас шал хүртэлх хаалттай, түгжээтэй хаалгатай байлгах зэргээр хувийн нууцлалыг хангахаар байгуулсан уу? | | | | |
| Эрэгтэй, эмэгтэй хүмүүст зориулсан ариун цэврийн болон бие засах газар тусдаа байдаг уу? | | | | |
| **Жорлон** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Бие засах газар, шээлтүүр хангалттай тоотой юу? | | | | |
| Жорлонг хүртээмжтэй, тухтай байрлуулсан уу? | | | | |
| **Шүршүүр / угаалгын өрөө болон бусад ариун цэврийн байгууламжууд** | | | | |
| Шүршүүрийн шалыг хальтиргаанаас хамгаалах хатуу, угаахад хялбар материалаар хийсэн үү? | | | | |
| Угаалтуур, шүршүүр/угаалгын өрөө хангалттай тоотой юу? | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Ариун цэврийн байгууламж тохиромжтой газар байрладаг уу? | | | | |
| Шүршүүр нь хүйтэн, халуун устай юу? | | | | |
| **Хоолны газар, гал тогоо, угаалгын өрөө** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Хоолны газар, гал тогоо, угаалгын өрөө хүртээмжтэй, цэвэрлэхэд хялбар материалаар баригдсан уу? | | | | |
| Хоолны газар, гал тогоо, угаалгын өрөө ариун цэврийн шаардлага хангасан уу? | | | | |
| Ажилчид өөрсдөө хоолоо хийх гал тогооны өрөө нь унтлагын өрөөнөөс тусдаа байдаг уу? | | | | |
| **Хувцас угаалгын өрөө** | | | | |
| Хувцасыг угаах, хатаах нөхцлөөр хангасан уу? | | | | |
| **Хоолны газар, гал тогоо** | | | | |
| Ажилчид гуанзанд хангалттай зай талбайгаар хангагдсан уу? | | | | |
| Хоолны газрууд хангалттай тохижилттой юу? | | | | |
| Гал тогоо нь хувийн ариун цэврийг сахих нөхцөлөөр хангагдсан уу? | | | | |
| Хоол бэлтгэх газрууд хангалттай агааржуулалттай юу? | | | | |
| Гал тогооны өрөөний шал, тааз, хана, хоол хүнс бэлтгэх, хоол хийх талбайн ойр, түүнээс дээш гадаргууг уур шингээдэг, удаан эдэлгээтэй, хоргүй, цэвэрлэхэд хялбар материалаар барьсан уу? | | | | |
| Хана нь галд тэсвэртэй материалтай, хоол хийх бэлтгэх ширээ нь гөлгөр, бат бөх, зэврэлтгүй, хоргүй, угааж болдог гадаргуугаар тоноглогдсон уу? | | | | |
| Хоол хийх сав суулга, тоног төхөөрөмжийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, хадгалахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан уу? | | | | |
| Хүнсний болон бусад хог хаягдлыг хадгалахад хангалттай битүүмжилсэн сав байдаг уу? Хог хаягдлыг хуримтлуулахгүйн тулд гал тогооны өрөөнөөс байнга гаргаж авдаг уу? | | | | |
| **Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын стандартууд** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Хүнсний аюулгүй байдалтай холбоотойгоор ДЭМБ-аас гаргасан "Аюулгүй хүнсний 5 түлхүүр" -г мөрддөг уу? | | | | |
| Ажилчдын хоол хангалттай тэжээллэгтэй юу? | | | | |
| Хоол нь ажилчдын шашин, соёлоос шалтгаалах онцлогыг харгалздаг уу? | | | | |
| **Эмнэлгийн байгууламж** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Анхны тусламжийн хэрэгсэл хангалттай тоогоор хангагдсан уу? | | | | |
| Анхны тусламжийн хэрэгсэл хангалттай нөөцтэй байна уу? | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Анхны тусламж үзүүлэхээр бэлтгэгдсэн ажилтан/ажилчид хангалттай байгаа юу? | | | | |
| Ажлын байранд эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг үү? Үгүй бол яагаад? | | | | |
| **Амралт, нийгмийн болон харилцаа холбооны хэрэгсэл** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Ажилчдад цуглах, амралт чөлөөт цагаа өнгөрөөх талбайтай юу? | | | | |
| Ажилчдад шашны зан үйл хийх зориулалтын байраар хангагдсан уу? | | | | |
| Ажилчид худалдаж авч чадахуйц эсвэл нийтэд хэрэглэгддэг үнэтэй утсаар холбогдож чадах уу? | | | | |
| Ажилчид интернет ашиглах боломжтой юу? | | | | |
| **Ажлын байрыг удирдан зохион байгуулах** | | | | |
| **Удирдлага, ажилтнууд** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Ажилчдын байрны менежментийн талаар, ялангуяа эрүүл мэнд, аюулгүй байдал (гамшиг осол, цар тахлын үед авах хэмжээг оролцуулан) харуул хамгаалалт, хөдөлмөрлөх эрх, орон нутгийн иргэдтэй харилцах харилцааны чиглэлээр нарийн боловсруулсан төлөвлөгөө, бодлого байдаг уу? | | | | |
| Гэрээт байгууллагатай бол бол тэдний гэрээний хариуцлага, тайлагнах үүргийг тодорхой тусгасан уу? | | | | |
| Ажилчдын байрыг удирдахаар томилогдсон хүн шаардлагатай мэдлэг, ур чадвар, туршлагатай эсэх, үүнд зохих хариуцлага, эрх мэдэл олгосон уу? | | | | |
| Орон байрны стандартыг (ялангуяа цэвэрлэгээ, хоол хийх, харуул хамгаалалт) мөрдөх хангалттай боловсон хүчин бий юу? | | | | |
| Ажилтнуудыг орон нутгаас ажилд авсан уу? | | | | |
| Ажилтнууд эрүүл ахуй, аюулгүй байдлын үндсэн сургалтад хамрагдсан уу? | | | | |
| Гал тогоонд ажиллах хүн нь хоол тэжээл, хоол боловсруулах талаар тусгайлан бэлтгэгдсэн, зохих хяналтыг хийдэг үү? | | | | |
| **Талбай дээрх эрүүл мэнд, аюулгүй байдал** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Цахилгаан, механик, бүтэц, хүнсний аюулгүй байдал зэргийг багтаасан эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлсэн үү? | | | | |
| Байрны менежер нь тодорхой өвчин, хоолны хордлого, хохирогчдын талаар эрүүл мэндийн байгууллагад мэдээлэх үүрэгтэй юу? | | | | |
| Анхны тусламж үзүүлэх чиглэлээр бэлтгэгдсэн ажилтан/ажилчид хангалттай тооны байгаа юу? | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Галын аюулгүй байдлын тусгай, зохистой менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлсэн үү? | | | | |
| Архи, мансууруулах бодис, ХДХВ/ДОХ болон эрүүл мэндийн эрсдэлтэй холбоотой бусад үйл ажиллагааны талаар ажилчдад зааварчилгаа өгдөг үү? | | | | |
| Ажилчид эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх өрөө, эмнэлгийн ажилтнууд, шаардлагатай бол эмэгтэй эмч/сувилагч байгаа юу? | | | | |
| Эрүүл мэнд, галын аюулгүй байдлын онцгой байдлын төлөвлөгөөг боловсруулсан уу? | | | | |
| Нөхцөл байдлаас шалтгаалан онцгой байдлын (газар хөдлөлт, үер, хар салхи) тусгай төлөвлөгөө бэлтгэсэн үү? | | | | |
| **Ажилчдын байрны харуул хамгаалалт** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Ажилчдыг хулгай, халдлагаас хамгаалах тодорхой арга хэмжээнүүдийг багтаасан харуул хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлсэн үү? | | | | |
| Хүч хэрэглэх тухай тодорхой заалт бүхий аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлсэн үү? | | | | |
| Харуул хамгаалалтыг ажилтнуудыг урьд өмнө нь гэмт хэрэг, зөрчилд холбогдсон эсэхийг шалгасан уу? | | | | |
| Хамгаалалтын ажилтнуудыг ажилд авахдаа эрэгтэй эмэгтэй хүйсний хүн байлгах асуудлыг авч үзсэн үү? | | | | |
| Хамгаалалтын ажилтнууд өөрсдийн үүрэг, хариуцлагын талаар тодорхой зааварчилгаа авсан уу? | | | | |
| Хамгаалалтын ажилтнууд гэр бүлийн хүчирхийлэл, хүч хэрэглэхтэй тэмцэх талаар зохих сургалтад хамрагдсан уу? | | | | |
| Биеийн үзлэгийг зөвхөн онцгой тохиолдолд тусгайлан бэлтгэгдсэн аль аль хүйсийн хамгаалалтын ажилтнаар хийдэг үү? | | | | |
| Аюулгүй байдлын ажилтнууд ажилчдын эрх, эргэн тойрны иргэдийн эрхийг хүндэтгэхийн чухлын талаар сайн ойлголттой болж, зохих ёс зүйг баримталдаг уу? | | | | |
| Ажилчид болон олон нийт харуул хамгаалалтын зохицуулалт, ажилтнуудын талаар санал гомдлоо боломжтой юу? | | | | |
| **Ажилчдын байран дахь ажилчдын эрх дүрэм, журам** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Ажилчдын орох гарах хөдөлгөөнийг хорих хязгаарлалттай юу? | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Ойролцоох орон нутаг зорчих тээврийн хэрэгслээр хангадаг уу? | | | | |
| Ажилчдын иргэний үнэмлэх бичиг баримтыг хураахыг хориглосон уу? | | | | |
| Ажилчдын эвлэлдэн нэгдэх эрхийг хүндэлдэг үү? | | | | |
| Ажилчдын шашин шүтлэг, соёл, нийгмийн гарал үүслийг хүндэтгэдэг үү? | | | | |
| Ажилчдад эрх, үүргийнхээ талаар ойлгуулж, байрны дотоод дүрэм, журам, шийтгэлийн механизмын хуулбарыг өөрсдийн ойлгодог хэлээр эсвэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр олгож байна уу? | | | | |
| Байрны дотоод дүрэм журам нь ялгаварлан гадуурхаагүй, шударга, үндэслэлтэй юу? | | | | |
| Архи, тамхи болон гуравдагч этгээдийн байранд нэвтрэх журам тодорхой бөгөөд ажилчдад ойлгуулсан уу? | | | | |
| Сахилгын арга хэмжээг хэрэгжүүлэх, тэр дундаа ажилчдын өөрийгөө хамгаалах эрхийг шударга, ялгаварлан гадуурхахгүй шийдвэрлэх журамтай юу? | | | | |
| **Зөвлөлдөх, гомдол гаргах механизм** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Ажилчидтай зөвлөлдөх механизмыг боловсруулж, хэрэгжүүлсэн үү? | | | | |
| Ажилчдад хөдөлмөрлөх эрх, ажиллах орчны талаар стандартын дагуу гомдол гаргах механизмтай юу? | | | | |
| Байранд болсон үйл явдлаас үүдэн сахилгын асуудлыг шударга, ил тод, талуудыг сонсож шийтгэл оноодог, шийтгэл хүлээсэн ажилчид шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шалгуулах боломжтой юу? | | | | |
| Ажилчдын дундах мөргөлдөөн, зөрчлийг шударга шийдвэрлэх механизм бий юу? | | | | |
| Ноцтой гэмт хэрэг гарсан тохиолдолд цагдаагийн байгууллагатай бүрэн хамтран ажиллах механизм бий юу? | | | | |
| **Олон нийттэй харилцах менежмент** | **Тийм** | **Үгүй** | **Хамаарахгүй** | **Тайлбар** |
| Олон нийттэй харилцах менежментийн төлөвлөгөөнд иргэдтэй байнгын мэдээлэл солилцох, зөвлөлдөх боломжтой харилцааны механизмыг бий болгохыг тусгасан уу? | | | | |
| Иргэдтэй харилцах асуудал хариуцсан албан тушаалтан томилсон уу? | | | | |
| Ажилчдын байртай холбоотой үүсэх нөлөөлөл тогтмол хянаж, эрсдлийг багасгаж, сайжруулдаг уу? | | | | |
| Иргэдийн төлөөлөгчдөд санал бодлоо илэрхийлэх, гомдол гаргах хялбар тогтолцоотой юу? | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө, мэдээлэл авахтай холбоотой стандартын дагуу олон нийтийн гомдлыг ил тод, үр ашигтай шийдвэрлэдэг тогтолцоотой юу? | | | | |

*Эх сурвалж:*
Worker's Accommondation: Processes and Standards, A Guidence note by IFC and EBRD https://www.ifc.org/en/insights-reports/2000/publications-gpn-workersaccommodation

---oOo---